



“УВС ХУНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 24/01

Улаангом сум

「Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон
хурлыг хүчин төгөлдөр тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн
Тооллогын комиссоос **ТОГТООХ** нь:

1. Нийт хувьцаа 12,716 саналын эрхтэй энгийн хувьцааны 99,8 хувийг эзэмшиж
буй нэг хувьцаа эзэмшигч биеэр хүрэлцэн ирж хуралд оролцож байгааг үндэслэн
компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох саналыг
хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.

2. Тооллогын комисст ирүүлсэн 112,532 саналын эрхтэй тус бүр 1, нийт 1 саналын
хуудсыг хүчинтэйд тооцсугай.

Тооллогын комиссын дарга



Ж.БААСТ



“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 24/02

Улаангом сум

Саналын хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйл, 72 дугаар зүйл, 72 дугаар зүйлийн 72.1.1 дэх заалтыг үндэслэн Тооллогын комиссоос **ТОГТООХ** нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдэгдсүгэй.

- Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж батлах

Зөвшөөрсөн 112,532 ширхэг хувьцаа буюу 100 хувь, Татгалзсан 0, Түтгэлзсэн 0,

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

Зөвшөөрсөн 112,532 ширхэг хувьцаа буюу 100 хувь, Татгалзсан 0, Түтгэлзсэн 0,

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах

Зөвшөөрсөн 112,532 ширхэг хувьцаа буюу 100 хувь, Татгалзсан 0, Түтгэлзсэн 0,

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан томилох тухай

Зөвшөөрсөн 112,532 ширхэг хувьцаа буюу 100 хувь, Татгалзсан 0, Түтгэлзсэн 0,

2. Санал хураасан асуудал бүрээр хувьцаа эзэмшигчдээс өгсөн зөвшөөрсөн санал нь Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасан хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувьд хүрсэн тул хурлын шийдвэрийг батлуулах саналыг хуралд танилцуулсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Ж.БААСТ



“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 24/03

Улаангом сум

□ Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг □
хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтын дагуу компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн хангалттай гэж дүгнэснийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.МӨНХНАРАН



“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 24/04

Улаангом сум

Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудитын дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дүгээр заалтын дагуу компанийн санхүүгийн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүний аудитын дүгнэлтийг хэлэлцэн хангалттай гэж дүгнэснийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.МӨНХНАРАН



“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 24/05

Улаангом сум

Компанийн 2024 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөг хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.9 дэх заалтын дагуу компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн шийдвэрлэснийг үндэслэн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн шийдвэрлэснийг үндэслэн хавсралтаар баталсугай.

2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин улирал бүр тайлагнан ажиллахыг Стратеги төлөвлөлт, инновац хариуцсан захирал З.Цэцэгсүвд, Маркетинг, борлуулалтын албаны дарга Э.Батзаяа, Санхүү албаны дарга Я.Мөнхжаргал, Чанар, үйлдвэрлэлийн албаны дарга Т.Өлзийтэгш, Захиргаа, хүний нөөцийн албаны дарга О.Оюунхүү нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.МӨНХНАРАН



“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 24/06

Улаангом сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалт, Компанийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Дараах нэр бүхий хүнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр сонгосугай.

1. Лхагвасүрэн овогтой Мөнхнаран
2. Түнжин овогтой Лхагвасүрэн
3. Лхагвасүрэн овогтой Нямгэрэл
4. Лхагвасүрэн овогтой Мөнхтуяа
5. Лхагвасүрэн овогтой Энхтуяа
6. Лхагвасүрэн овогтой Батмөнх

2. Дараах нэр бүхий хүнийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Азай овогтой Чимид-Очир
2. Жачин овогтой Бааст
3. Нэмэхжаргал овогтой Оюун

3. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнээр улиран томилогдож буй гишүүдэд компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.МӨНХНАРАН